

Осолд хүргэж болзошгүй тохиолдлыг мэдээлэх, судлан шинжлэх

2018 оны 3-р сар

1986 оны 1-р сарын 28-ны өдөр Флорида мужийн Кейп Канавералд АНУ-ын “Чалленжер” нэртэй сансрын хөлөг хөөрснөөсөө хойш 73 секундын дараа дэлбэрсэн (1, 2). Тус хөлөг бүрмөсөн сүйрсэн бөгөөд нислэгийн багийн нийт долоон гишүүн бүгд амиа алдсан. Үүний шууд шалтгаан бол хатуу түлшт пуужингийн хөдөлгүүрийн холбогчоос халуун хий алдагдсантай холбоотой байсан. Алдагдсан халуун хий нь устөрөгчийн шингэн агуулсан танканд хүрч цоолсон учир танк дэлбэрсэн. Хатуу түлшт пуужингийн хөдөлгүүрийн холбогч эд ангиудыг үндсэн болон туслах резинэн жийргээр бэхэлсэн байсан. Сансрын хөлөг хөөргөсөн өдөр бага температурын улмаас холбоосон дээрх хоёр жийргэвчний бэхэлгээ хоёулаа задарсан. Үүний өмнө хэд хэдэн удаа хөөргөлт хийгдэх үед үндсэн жийргэвч задарсан хэдий ч туслах жийргэвчний тусламжтайгаар хатуу түлшт хөдөлгүүрийн найдвартай байдлыг амжилттай хадгалж чадсан. Өмнө илэрсэн эдгээр доголдлууд нь осолд хүргэж болзошгүй тохиолдлууд байсан хэдий ч нарийвчлан шалгаж судлахаар ноцтой гэж тооцоогүй аж.

Осолд хүргэж болзошгүй тохиолдлуудыг мэдээлэхгүй, нарийвчлан шалгаж судлахгүй орхих нь үйлдвэрлэлийн осол гарах нэг шалтгаан болсоор ирсэн. Жишээ нь: 1998 оны 4-р сарын 8-ны өдөр Нью-Джерси мужийн станцад температурын горим алдагдсаны улмаас 2000 галлоны реакторын (3) даралт хэт ихэсж, гал (4) ба дэлбэрэлт үүссэн. Ослоор 9 ажилтан гэмтсэн бөгөөд 2 нь онц ноцтой бэртсэн. Операторуудын хувьд тухайн үед мөрдөгдөж байсан процедурууд болон боломжтой хөргүүрүүдийг ашигласан ч температурыг хянаж чадаагүй. Өмнө нь операторууд температурыг заасан дээд хязгаараас доош түвшинд тогтоож чадаагүй тохиолдол 6-аас доошгүй удаа гарч байсан хэдий ч температур аюул учруулахаар өндөр түвшинд хүрч байгаагүй аж. Тэдгээр осолд хүргэж болзошгүй урьдчилсан тохиолдлуудыг тухайн үед нь нарийвчлан шалгаж судлаагүй байна.



1

2

Хатуу түлшт пуужингийн гоожилт үүссэн холбоос

Хатуу түлшт пуужин

“Чалленжер” хөлөг

3

4

Та мэдэх үү?

- Олон тохиолдолд үйлдвэрлэлийн ноцтой ослын дараа судалгаа шинжилгээний багийнхан тухайн осол гарахаас өмнө ямар нэгэн анхааруулах болон осолд хүргэж болзошгүйг сэрэмжлүүлэх нөхцөл байсан гэдгийг олж тогтоодог. Хэрэв тэдгээрийг мэдээлж, нарийвчлан шалган судалж, судалгааны үр дүнд илэрсэн шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн бол ноцтой осол тохиолдохоос сэргийлэх боломжтой байсан.
- Бид бүгд осолд дөхсөн тохиолдлоос сургамж авах нь ноцтой осол гарахаас дээр гэж үздэг. Учир нь энэ түвшинд хүн гэмтэж бэртээгүй, гарз хохирол бага байдаг.
- Осолд дөхсөн тохиолдлын талаар хэн нэгэн хүн мэдээлэхгүй л бол шалган судлах ажил явагдах боломжгүй! Осолд хүргэж болзошгүй тохиолдлуудыг хүмүүс анхаарахгүй эсвэл аюулыг нь ойлгож ухамсарлахгүй байгаа тохиолдолд хэн ч мэдээлэхгүй.
- Үйлдвэрлэлийн процессыг аюулгүй явуулахын тулд хяналт зайлшгүй шаардлагатай. Хэрэв танай ашиглалтын процессын хувьд үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны аль нэг чухал параметрийг тусгайлан заасан түвшинд барих боломжгүй буюу хянаж чадахгүй байгаа тохиолдолд осолд хүргэж болзошгүй нөхцөл гэж тооцох ёстой.
- Аваарын хамгаалах төхөөрөмж эсвэл нөөц хэрэгслүүдийн аль нэг нь идэвхжсэн бол осолд дөхсөн тохиолдол гэж үзнэ. Учир нь тухайн төхөөрөмж доголдсон бол юу болох байсан бэ?

Та юу хийж чадах вэ?

- Танай үйлдвэрт мөрдөгддөг осол болон осолд дөхсөн тохиолдлыг мэдээлэх, судлан шинжлэхтэй холбоотой тогтолцоотой танилц. Хэрэв танайд тийм тогтолцоо байхгүй бол удирдлагын багтаа хандан тийм тогтолцоо хэрэгжүүлэх санал дэвшүүл.
- Бүх осолд дөхсөн тохиолдлыг мэдээл. Үүнд үйлдвэрлэлийн процессыг ашиглалтын аюулгүй түвшинд хянаж чадаагүй болон аваарын хамгаалах төхөөрөмж, нөөц хэрэгслүүдийн ажиллагаатай холбоотой тохиолдлууд ч багтана.
- Ахлах ажилтан, менежер, техникийн ажилтнууд ажлын бүртгэлийн хуудас, нарийн хэмжүүрийн хэрэгслийн заалт болон бусад мэдээллийг уншаад осолд хүргэж болзошгүй тохиолдлыг олж анзаарна гэж бүү найд. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад маш их мэдээлэл цуглардаг ба осолд хүргэж болзошгүй нөхцлүүд нь мэдэгдэхгүй орхигдох боломжтой. Хэрэв та ямар нэгэн осолд хүргэж болзошгүй нөхцлийг олж анзаарвал удирдлагын багтаа мэдэгдэх нь тань үүрэг хариуцлага юм.
- Осолд хүргэж болзошгүй нөхцөл мөн эсэхэд эргэлзэж байсан ч мэдээл. Мөн осолд хүргэж болзошгүй нөхцлийг танихын тулд “үүнээс муу юу тохиолдож болох байсан бэ?” гэж бод.
- Танай үйлдвэрт гарсан осол болон осолд дөхсөн тохиолдлын судалгааны ажилд сайн дураараа оролц.

Танай үйлдвэр осолд хүргэж болзошгүй нөхцлөөр дамжуулан аюул ойрхон байгааг сануулж байна – үүнийг анхааран “сонсож” буй хүн байна уу?